

22. Бурхан минь, Финлянд дахь TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" баг дэлхийн өнцөг булан бүрт байгаа эмэгтэйчүүдийн төлөөх залбиралд залуу хойч үеийнхнийг сонирхуулж, татан оролцуулах арга замуудыг олоосой гэж бид залбирч байна. (Иоел 1:3)

23. Бид дорд үзэгдэж, хүчирхийлүүлж, гудамжинд хөөгдөж, явах газаргүй болсон Дани эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Бурхан минь, Та шударга бусаар зовж шаналж буй хүмүүсийг харж байгаа бөгөөд тэдний зовлон зүдгүүрийг авч, тэдэнд хайр энэрэлээ тусгаач! (Эх. 16:13).

24. Эзэн минь, эмэгтэйчүүдийн амьдралд нөлөөлж, таныг алдаршуулахын тулд хөтөлбөр зохиож байгаа Румын TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" багийнханд мэргэн ухаан, урам зориг хайрлаач. (Евр. 13:21).

25. Тэнгэрлэг Эцэг минь ээ, Сербид үр хүүхэдтэй болж чадахгүй гэр бүлүүд улам бүр нэмэгдэж байна. Тэдэнд итгэл найдвар, эдгэрэлт, тайвшралыг өгөхийг бид танаас хүсч байна. Төрсөн эцэг эхийнхээ хайхрамжгүй хандан өнчин хоцорсон хүүхдүүдийг үрчлэн авах эсвэл өөр арга замаар тэдэнд тусалж тайвшруулаач. (Дуу. 113:9)

26. Хүндэт Бурхан минь, Болгар дахь цыган хүүхдүүдийг соёлын онцлогын өөрчлөх шаардлагагүйгээр амьдрах ухааныг эзэмшүүлэх, амжилтанд хүрэх тэгш боломжийг олгох үүднээс сургуульдаа нэгтгэж өгөөсэй гэж бид залбирч байна. (Ег. 22:21).

27. Аав аа, Гренландад архи, гашишийн донтолын хэлхээг таслаач. Энэ хорон муу зуршил нь шоронд хоригдох, аллага, амиа хорлоход нь нөлөөлсөн. Тэд таниас эрх чөлөөг олж, муу зуршлаасаа салах болтугай. (Еф. 5:18)

28. Эзэн минь, бид таниас бусад залуучуудад ирээдүйн итгэл найдварыг тань түгээж чадах залуу Христийн шашны удирдагчдыг Шведэд төрүүлээсэй гэж хүсч байна. (Еф. 5:29)

29. Бурхан минь, бид Португалийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн төлөө залбирч байна. Гэр орон, хүүхдүүдээ асран халамжлах ажлыг хамтдаа хийж, хариуцлагаа тэнцвэртэй үүрэх ёстойг нь ойлгуулаач. (1 Тим. 3:5)

30. Аав аа, Европ дахь хүний наймааны золиос болсон эмэгтэй бүрийг хамгаалж, эрх чөлөөнд нь чиглүүлээрэй. Далд эрдэнэсийн хөтөлбөрүүд нь сонсогчдод Бурханы нүдэн дэх өөрсдийн үнэ цэнийг мэдэхэд нь туслах болтугай. (Дуу. 139:14).

31. Бурхан минь, Молдав дахь "Румын Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг сонсож буй хүмүүсийн амьдралд та хүрээч. Молдавын сайн дурынхныг авчирч, тэнд үйлчлэлээ хөгжүүлэхэд нь тусалаач. (Дуу. 51:10).

후원안내
국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанлиг 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2022. 3. Европ эмэгтэйчүүдийн төлөөх залбирал

Европ нь нийт 45 улсаас бүрдэх бөгөөд янз бүрийн хэл соёл зэрэгцэн оршдог. Европын хүн амын 72% нь христитгэл, 7% нь ислам, 20% нь шашингүй үзэлтэй. Найдвартай эмэгтэйчүүдийн баг нь видео болон зөвлөгч, удирдагч нарыг бэлтгэх сургалтаар дамжуулан дараа үеийн христитгэлт удирдагч нарыг сурган бэлтгэхээр хичээнгүйлэн ажиллаж байна. Европчууд "хэлбэр(хээ) төдий" христэд итгэгчээр бус харин үнэнээр Христийг Эзэн хэмээн хүлээн авч үйлчилдэг жинхэнэ итгэгч нар болохын төлөө залбирч өгөөрэй~

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Эзэн минь, 2020 оны 12-р сард газар хөдлөлт болсон Хорватын Петриня, Глина, Сисак дахь ард түмний төлөө залбирч байна. Тэдний олонхи нь ядуурч, гадны тусламж авч чадахгүй хүйтэн контейнер дотор амьдарч байна. (Дуу. 40:17)

2. Италид 3 эмэгтэйчүүд тутмын нэг нь бэлгийн болон бие махбодийн хүчирхийлэлд өртсөн байдаг.Тэдний ихэнх нь хүчирхийллийнхээ талаар бусдад мэдээлэлхээс айдаг. Аав аа, эдгээр эмэгтэйчүүдийг эдгээж, гэмт хэрэг үйлдэж буй хүмүүсийн зүрх сэтгэл, оюун ухаанд жинхэнэ өөрчлөлтийг авчираач. (Дэд хууль 31:6)

3. Бурхан минь, Орос улсад сайн дурынхныг цуглуулж сар бүр мусульман гэр бүлд очиж нөхөрлөж, Христийг хуваалцах боломжийг олгооч. Мусульман эмэгтэйчүүд нөхрөөсөө айхгүй байж,тэд хамтдаа Есүс Христийг хүлээн авах болтугай! (Сур. 29:25)

4. Эзэн минь, бид Далд эрдэнэсийг үйлдвэрт ажиллаж байгаа Испани дахь TWR-ийн “Найдвар доторх Эмэгтэйчүүд” багийн төлөө залбирч байна. Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлийг таны хайрыг тухай сонсоход нь бэлэн байлгаач. (Ром. 5:8)

5. Болгар эмэгтэйчүүдийн гуравны нэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байна. Эдгээр эмэгтэйчүүдийг хамгаалж, амгалан тайван байлгаач. Аав аа, тэднийг айх зүйлгүй, тайван байхын тулд зугтах арга зам, тусламж авах газарыг зааж өгөөч. (1 Кор. 10:13)

6. Бурхан минь, бид Даничуудыг Есүсийг Аврагч хэмээн хүлээн зөвшөөрөөсэй гэж хүсэн, тэдний дахин сэргэлтийн төлөө залбирч байна. Norea Media номлолыг Данийн ард түмэнд сайн мэдээг түгээх хэрэгсэл болгоосой гэж бид хүсч байна. (Ром. 13:11)

7. Эзэн минь, бид Сербид амьдардаг цыгануудын төлөө залбирч байна. Тэд сайн ажил олж хийхийн тулд, ядуурлаас гарахын тулд сургуульдаа үлдэж,боловсрол эзэмшхэд нь туслаач. Түүнчлэн цыган охид, хөвгүүдийг насанд хүрээгүй гэрлэлтийг зогсоогоосой гэж бид хүсч байна. (1 Сам. 2:8)

8. Аав аа, та биднийг аминчхан үзэлтэй биш, харин нийгмийн амьдралд сайнаар нөлөөлдөг итгэгчид байгаасай гэж уриалдаг. Нидерландын ард түмэн болон баруунийханий ертөнцийн хандлагыг даруу байлгаж, би биш бид гэсэн хандлагатай болгон,бусдыг хүндлэх сэтгэлтэй болгон өөрчилөөч! (Филиппой 2:3)

9.Хорио цээрийн арга хэмжээ үргэлжилж байгаа хэдий ч 2021 онд анх ажлаа эхлүүлж байсан Финландын TWR "Найдвар доторх Эмэгтэйчүүд" дөрвөн шинэ залбирлын бүлэг нээж байсан Бурханыг маггъя. Харин одоо Финландад 111 залбирлын бүлэг бий болсон байдаг.Их Эзэндээ маш их талархаж байна (1 Тес. 5:17).

10.Аав аа, та Румын христийн шашинтай эмэгтэйчүүдэд хүүхдүүддээ сайн үлгэр дуурайл болж, тэдний амьдралд тохиолдох саад бэрхшээлийг таны хүслийн дагуу хариулахад нь туслаач гэж бид залбирч байна. (Сургаалт үгс 22:6).

11. 2021 онд TWR "Найдвар доторх Эмэгтэйчүүд" сэтгүүлийг үндэслэгч Марли Спикерийн тухай намтар нь герман хэл дээр хэвлэгджээ. Олон хүн энэ номыг уншиж, үйлчлэлд оролцох болтугай гэж хүсэж байна. (Үйлс 6:7)

12.Аав аа, Норвеги дахь ганц бие эмэгтэйчүүд таныг хайрлаж, үнэлж байгааг мэдэрч, Сүм болон нийгэмд гүйцэтгэх үүрэг зорилгоо олж авах болтугай. (1 Иохан 4:19)

13. Эзэн минь, Францад маш олон хүн Христийн шашинд итгэдэггүй бөгөөд хүн амын тал хувь нь танд итгэдэггүй. Итгэгчид үг болон үйлдлээрээ таныг гэрчлэн амьдрах болтугай. (1 Петр 2:12)

14. Бурхан минь, Португал дахь манай TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" багийг одоогийн сэдвүүддээр тулгуурлан, тэнд байгаа орон нутагийн эмэгтэйчүүдэд тохирсон олон хөтөлбөр зохиоход чиглүүлээч. Та тэдний амьдралд хүрч, тэднийг өөрчилж, Есүсийн талаарх жинхэнэ мэдлэг рүү хөтлөх болтугай. (Үйлс 4:12)

15. Тэнгэрлэг Эцэг минь ээ, бид Польш дахь TWR-ийн "Найдвар доторх Эмэгтэйчүүд" багийг үйлчлэлээ улам бэхжүүлж, хөтөлбөр боловсруулж байх үед нь удирдамж, урам зоригийг өгөөсэй гэж таниасаа хүсч байна. (2 Петр 1:21)

16. Бурхан минь, бид Шведэд сэтгэлзүйн хямралд орж байгаа залуу эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Тэдэнд сэтгэлийн хүчтэй байхад нь туслаж, өөрийнхөө жинхэнэ дүр төрхийг таниас эрж хайн олох болтугай. (2 Кор. 5:17)

17. Эзэн минь, бид Украины TWR дахь эмэгтэйчүүдийн яамын шинэ удирдагчдыг ерөөн залбирч өгөв. Та дараагийн улиралд үйлчлэх үйлчлэлийн багийнханд мэргэн ухаан, хүч чадал удирдамжийг өгөөсэй гэж бид хүсч байна. (Дуу. 24:4–5)

18. Бид Гренландад үйлчилж буй Христэд итгэгч эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Тэдний олонх нь хүүхэд насаа хүнд хэцүү туулж, багадаа авч байсан сэтгэл болон биеийн гэмтлээ эдгээх шаардлагатай байна. Та тэднийг эдгээж, сэргээж, босгож, шинэчлээч! (Дуу. 146:3).

19. Албани эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь амьдралынхаа туршид гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байдаг. Аав аа, тэднийг аварч эдгээхийн тулд өөртөө татаарай. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамгаалах байр ажиллуулдаг хүмүүст эдгээр зовж шаналж буй эмэгтэйчүүдийн төлөөх таны хайр болоод мэргэн ухаанаар дүүрэн байх болтугай. (Иер. 17:14).

20. Бурхан минь, Фарерын арлуудад залбирлын хуанли орчуулж буй хүмүүст хүч чадал, мэргэн ухааныг өгөөч. Тэндхийн зүүчлан залбирагч нар тантай гүн гүнзгий харилцаа тогтоохыг эрэлхийлэх болтугай. (Сур. 2:6)

21. Аав аа, бид Швейцарь дахь сүмүүдэд эв нэгдлийг хүсч байна. Таны тусламжтайгаар тэд аливаа санал зөрөлдөөнөө шийдэж, сайн мэдээндээ анхаарлаа төвлөрүүлэх болтугай. (1 Кор. 1:10)